



79 Page



80 Page



81 Page



82Page

Иосеф 1

-Joseph1-

Тайлбарлагч Иаков арван хоёр хүүтэй байжээ. Иаков тэдний дундаас арван нэг дэх хүү болох Иосефыг илүү их хайрладаг байв. Нэгэн удаа эцэг нь түүнд урт тансаг дээл хийлгэн өмсүүлжээ. Үүнд ах нар нь дургүйцэж, эцгийн хайрыг илүү хүртсэн Иосефийг үзэн ядаж байлаа.

Тайлбарлагч Иосеф маш их зүүдэлдэг байсан ба нэг өдөр ах нартаа зүүдээ ярив.

Иосеф Ах нар аа! Би өнгөрсөн шөнө зүүд зүүдэллээ. Та бүхний боож

Тайлбарлагч тавьсан сүрэл миний боосон сүрлийг тойрон цуглаад түүнд мөргөж байсан. Би бас өөр нэг зүүд зүүдэллээ. Энэ удаа нар, сар, бас арван нэгэн од надад мөргөцгөөсөн.

Ах1 Юу гэнээ? Чи үнэхээр бидний хаан болно гэж үү? Зэвүүн амьтан!

Иаков Би бас ээж чинь, ах нар чинь үнэхээр чамд мөргөнө гэж үү? Дахиад тэгэж битгий хэлээрэй

Тайлбарлагч Иосефийн зүүдийг сонссон ах нар түүнд атаархаж, Эцэг Иаков нь Иосефийг зэмлэв. Гэвч тэрээр Иосефийн үгийг зүрхэндээ хадгалжээ.

Тайлбарлагч Нэгэн өдөр Иаков, Иосефийг хоньдоо хариулахаар явсан ах нар нь сайн байгаа эсэх талаар мэдээд ир хэмээн явуулав.

Ах1 Хараач, тэр зүүдлэгч ирж байна. Бүгдээрээ түүнийг алаад нүхэнд хаяцгаая.

Реубен Болохгүй ээ, түүнийг алж яах юм бэ? Зүгээр л нүх рүү хая.

Тайлбарлагч Ах нар нь Иосефийг алах гэсэн боловч Реубен тэднийг болиулсанд тэд түүнийг алсангүй. Харин Иосефийн бүх хувцасыг тайлаад нүхэнд хаяв. Иосеф ах нараасаа намайг нүхнээс гаргаач гэж хичнээн гуйсан ч, тэд тусалсангүй.

Ах1 Бүгдээрээ Иосефийг энд нь үхүүлэлгүй харин тэр хүмүүст худалдацгаая.

Ах2 Тэгье, сайхан санаа байна.

Тайлбарлагч Ах нар нь Иосефийг Египет уруу явж байсан худалдаачдад хорин мөнгөн зоосоор зарж орхижээ. Иосефийн өмсөж байсан урт сайхан дээлэнд ямааны цус түрхэв. Тэгээд тэд гэртээ харьцгаан аавдаа түүний хувцасыг үзүүлжээ.

Ах1 Аав аа, Иосефийг зэрлэг араатан бариад идчихжээ.

Иаков Яасан гэнээ? Иосеф үхсэн гэв үү? Энэ үнэн үү?

Ах2
Иаков

Тийм ээ аав аа. Хувцас нь энэ байна.
Ий ий ий Иосеф хүү минь! Даанч яав даа! Хөгшин би чамгүйгээр
яаж амьдрана даа! Иосеф ...Иосеф оо!



83 Page

Тайлбарлагч Иосефийг Египетэд аваачаад Фараоны түшмэл Потифарт худалджээ. Тэнд үнэнчээр ажиллаж байсан учир Потифартын зарц нарын ахлагч болжээ. Гэвч Иосеф Потифарын эхнэрт гүтгэгджээ.

Потифарын эхнэр Хань минь! Энэ муу Иосеф намайг доромжлохыг оролдлоо. Та түүнийг шийтгэж өгөөч!

Потифар Юу... юу гэнэ ээ! Иосеф олиггүй амьтан манай эхнэрт гар хүрч зүрхэлнэ гэнэ ээ! Түүнийг даруй барьж шоронд хорь!

Тайлбарлагч Эхнэрийнхээ худал үгэнд үнэмшсэн Потифар Иосефийг хааны хоригдлуудыг хорьдог шоронд хорив.



84 Page

Тайлбарлагч Иосеф энэ бүхэн худал гэдгийг хэлмээр байсан ч гомдлоо ил гаргасангүй. Хэдэн өдрийн дараа хааны сөнч болон талхчин хоёр Иосефийн байгаа газарт хоригдов. Гэтэл нэг өдөр тэр хоёр ихэд баргар царайтай сууж байлаа.

Иосеф Юу болов? Юунд ингэж уруу царайлав?

Сөнч Би нэг сонин зүүд зүүдэллээ. Миний өмнө усан үзмийн мод байв. Тэр мод гурван мөчиртэй бөгөөд ургаж дэлгэрээд усан үзэм боловсорчээ. Би шүүсийг нь шахан аяганд хийгээд Фараон хааны гарт өгч байна гэж зүүдэллээ. Энэ зүүд ямар утгатай юм болоо.

Иосеф Зүүдний тайлалыг би хэлж өгье. Гурван өдрийн дараа хааны өршөөлийн зарлиг гарах бөгөөд та суллагдан ордны ажилдаа дахин орох болно. Тэр үед та намайг марталгүй санаарай. Надад энэрэл хайраа үзүүлж хаанд энэ тухай хэлж намайг шоронгоос гаргаж өгнө үү.

Талхчин Хөөх, зүүдийг сайн тайлж байх чинь. Миний зүүдийг ч бас тайлаад өг! Би бол хааны талхчин. Миний зүүдэнд толгой дээр минь цагаан талхтай гурван сагс байв. Гэтэл шувууд миний толгой дээрх сагснаас талхыг авч идэж байсан.

Иосеф Зүүдний утга нь юу вэ гэхээр гурван өдрийн дараа хаан таны толгойг авч модонд өлгөхөд шувууд махыг чинь идэх болно.

Талхчин Юу юу...яана гэнэ ээ ?

Тайлбарлагч Гурван өдөр өнгөрч, бүх зүйл Иосефийн хэлснээр болов. Гэхдээ сөнч Иосефийг мартаж орхижээ.

Тайлбарлагч Тэр явдлаас хойш хоёр жил өнгөрчээ. Нэгэн өдөр Фараон хаан маш сонин зүүд зүүдэлжээ. Эхний зүүдэнд нь тарган сайхан долоон үхэр, турж эцсэн долоон үхэр байх агаад турж эцсэн долоон үхэр тарган сайхан долоон үхрийг идчихэв гэнэ.



85 Page



86 Page

Хоёр дахь зүүдэнд нь өтгөн сайхан долоон түрүү мөн хатаж хорчийсон долоон түрүү байх бөгөөд хатаж хорчийсон түрүүнүүд өтгөн сайхан долоон түрүүгээ залгисан тухай зүүд байлаа.

Фараон Үнэхээр сонин зүүд зүүдэллээ. Зүүд тайлах чадвартай бүх мэргэдийг дуудаж авчир.

Тайлбарлагч Хэн ч тэр зүүдийг тайлж чадсангүй. Энэ үед хааны сөнч өөрийн зүүдийг тайлж өгсөн Иосефийг гэнэт санав.

Сөнч Хаантан минь, би зүүд тайлдаг нэгэн мэргэн хүнийг мэднэ.

Тайлбарлагч Хаан хүн явуулж, Иосефийг дуудуулав. Иосефт Бурханы мэргэн ухаан дүүрэн байсан бөгөөд Фараон хааны зүүдийг тайлж чаджээ.

Иосеф Фараон хаантан минь! Энэ хоёр зүүд нэг л утгатай. Бурхан хийх гэж байгаа ажлаа танд харуулжээ. Энэ нутагт өнтэй сайхан долоон жил болж, дараа нь ган зудтай долоон жил залгах болно. Египетийн нутаг даяар их өлсгөлөн болох учир өнтэй сайхан жилдээ ургацаа сайн хурааж хадгалах хэрэгтэй. Тэгээд гантай долоон жилдээ хадгалсан ургацаа гамтай хэрэглэж чадвал өлсгөлөнд сүйрэхгүй байх болно. Хаан та даруй тушаал гаргаж энэ ажлыг хийх мэргэн ухаантай удирдагчийг томилогтун.

Тайлбарлагч Фараон хаан ихэд гайхлаа. Египетийн ямар ч мэргэдэд байхгүй мэргэн ухаан, түүнд байгааг мэджээ.

Тайлбарлагч Фараон хаан Иосеф болон олон түшмэдийн өмнө ингэж хэлэв. Иосеф Бурханы мэргэн ухаанаар дүүрэн хүн юм! Бурхан чамд энэ бүх зүйлийг мэдүүлсэн учир чам шиг мэргэн хүнийг хаанаас олох билээ.

Тайлбарлагч Хаан өөрийн тамгатай бөгжөө гарнаасаа мултлан Иосефт өгөв. Тэгээд Иосефийг Египетийн сайд болгожээ. Бурхан Иосефт гайхмаар зүүдийг өгсөн бөгөөд эцэст нь тэр зүүдний дагуу биелүүлж өгчээ. Бурхан Израильчуудыг аврахын тулд Иосефийг Египет уруу явуулж гайхамшигтай ажлаа хийлгэв. Энэ бүх зүйлд Бурхан үргэлж Иосефын хамт байсан юм.